

МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан болно.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу дараахь үе шаттайгаар хийв.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
3. Ойлгомжтой байдал;
4. Зардал;
5. Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал”-ын хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төслийн үндсэн зорилго нь мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх, төрөөс энэ төрлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллахад чиглэгдэж байгаад үндэслэн, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байгаа эсэхийг үнэлэв. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд

¹ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

“Практикт хэрэгжих боломж”-ын хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэхээр сонгов.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ын хүрээнд хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Ойлгомжтой байдал” –ын хүрээнд хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг тогтоох зорилгоор Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь төрийн байгууллага, хуулийн этгээдэд холбогдох зардал үүсгэхээр зохицуулсан байх тул уг хоёр субьектэд үүсэх зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Үндсэн хууль, Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

1.Манай улсад мөрдөгдөж буй хэд хэдэн бодлогын баримт бичигт төрийн зарим чиг үүргийг хууль гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлыг оновчтой зохицуулах талаар тусгагдсан байдаг ч концессийн гэрээгээр ажил гүйцэтгүүлэхээс бусад төрлийн үйл ажиллагаа хараахан бэхжээгүй байна.

2.Гэтэл бусад салбарын мэргэжлийн нэгдсэн холбоодын үйл ажиллагааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулдаг тул төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд төдийлэн ахиц гарахгүй, бэхжихгүй байгаа тул хууль эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлага үүсч байна.

Иймд Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой тул хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараахь байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд мэргэжлийн нэгдсэн холбоонд тавигдах шаардлагыг тусгасан 2 дугаар бүлгийг сонгон авч дүн шинжилгээ хийнэ.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 4 бүлэг, 19 зүйлтэй./

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо. /Хуулийн төсөл 4 бүлэг, 19 зүйлтэй./

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулья.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн 2, 3 дугаар бүлэг	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Төслийн 2 дугаар бүлэг	Ярилцлага, санал авах
4	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх

5	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах
---	-----------------	------------------------	---------------------------------------

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

Нэг. Зорилгод хүрэх байдал

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас харвал хуулийн төсөл боловсруулах эрх зүйн үндэслэл нь дор дурдсанаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.4-т “Тогтвортой хөгжлийн засаглал”-д “төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;” гэж, 2.4-ийн зорилго 2-т “Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.” гэж;
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.19-т “Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлого баримталж, хэрэгжилтийг хангах эрх зүйн орчинг цогцоор бүрдүүлнэ.” гэж;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор батлагдсан “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ын 3.1.1-д “нутгийн удирдлагын байгууллагын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх замаар улс төрийн төвлөрлийг сааруулах;”, 3.1.4-т “төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, төрийн болон орон нутгийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, нийгмийн салбарын хувьчлалыг үргэлжлүүлэх замаар эдийн засгийн төвлөрлийг сааруулах.” 4.1-ийн 2-т “төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чиг үүргийн 20-иос доошгүй хувийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж эхэлсэн байна;”, 4.2.1-т “яам, Засгийн газрын агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чиг үүргийг ангилж, зайлшгүй шаардлагатайгаас бусад чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж нийтийн албаны чиг үүргийг оновчтой болгосон байна;”.

Дээрх зорилт, арга хэмжээг үндэслэн Мэргэжлийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны зохион байгуулалт, чиг үүрэг, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн болон бусад төрийн

бус байгууллагатай хамтран ажиллах, харилцахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна гэж тусгасан байна.

Иймд хуулийн төслөөс дээрх зорилтуудтай холбогдсон, эдгээр зорилтуудыг хангах зорилгоор тусгагдсан зүйл заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг нь тооцно. Үүнд:

Д/д	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны зохион байгуулалт, чиг үүрэг, эрх зүйн байдлыг тодорхойлох,	Төслийн 2 дугаар бүлэг
2.	Төрийн болон бусад төрийн бус байгууллагатай хамтран ажиллах,	Төслийн 3 дугаар бүлэг

Зорилгод хүрэх байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хуулийн төслөөр тавьсан зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулан судлахад хуулийн төслийн зохицуулалт нь тавьсан зорилгуудад бүрэн хүрэх боломжтой байдлаар тусгагдсан гэж үзсэн.

Хоёр. Практикт хэрэгжих боломж

Монгол Улсад мөрдөгдөж хэд хэдэн бодлогын баримт бичиг, хууль тогтоомжид төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих талаар заасан байдаг. Манай улсад 27000 гаруй төрийн бус байгууллага бүртгэгдсэн ч тэдгээрийн үйл ажиллагаа нь тогтворгүй, мэргэшсэн байдал алдагдсан байдгаас төрийн зүгээс шинээр баталж буй хууль тогтоомж, дүрэм журамдаа иргэний нийгмийн оролцоо ялангуяа мэргэшсэн байгууллагын оролцоог төдийлөн тусгахгүй болж аливаа салбарт төрийн оролцоо ихэсч байна.

Нөгөө талаас мэргэшсэн холбоодын үйл ажиллагааг дэмжих, журамлах эрх зүйн орчин бүрэлдээгүйн улмаас төрийн байгууллагад зөвлөх, хамтран ажиллахад хүндрэл үүсч байгаа юм.

Иймд, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлж өгөх шаардлагад нийцүүлэн хуулийн төсөл боловсруулагдсан байна.

Гурав. Ойлгомжтой байдлыг судлах

Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл.Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг

шаардлага:	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.
30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй	Уг

байх;	шаардлагыг хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан.

Дөрөв. Хүлээн зөвшөөрөгдөх байдал: Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгааг салбар салбарын иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлттэй ярилцлага хийх, санал солилцох хэлбэрээр авсан ба нийт 3 удаагийн ярилцлагад 8 төрийн бус байгууллагын төлөөлөл оролцож 100 хувь дэмжсэн байр сууриа илэрхийлсэн байна.

Үүнээс үзвэл мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлыг тодорхой болгох эрх зүйн зохицуулалт хийхийг эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдүүд буюу төрийн бус байгууллагууд хүлээн зөвшөөрч байна гэж үзэж байна.

Тав. Зардал. Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу зардлын тооцоо хийх ажиллагааг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д тодорхой тусгасан.

Зургаа. Харилцан уялдаа: Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултуудад дараахь байдлаар хариулсан.

№	Асуултууд	Хариулт
1	хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм
2	хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм
3	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Тийм
4	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй
6	хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм
7	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг	Үгүй

	орхигдуулсан эсэх;	
8	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй
9	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тийм
10	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
11	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Ийм зохицуулалт байхгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй
13	хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм
14	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
15	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
16	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараахь баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан;
2. 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улын Их Хурлын гишүүн Н.Учралын баталсан Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хуулийн төслийн үзэл баримтлал, түүнд нийцүүлж боловсруулсан хуулийн төслийн хувилбар;
3. Нийт 8 төрийн бус байгууллагаас саналаа нэгтгэн боловсруулж ирүүлсэн хуулийн төслийн санал
4. Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он;

5.2. Үнэлэлт дүгнэлт

Энэхүү үнэлгээний ажлын явцад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзаж ярилцах, хэлэлцүүлэг зохион байгуулах, албан бичгээр санал авах, дотоод болон гадаадын улс орны сайн туршлага бүхий хуультай харьцуулах,

давхардал хийдлийг илрүүлэхээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэхээс гадна энэ асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны судалгааг ашигласан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт бүрээр дараахь байдлаар үнэлж дүгнэлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зорилго, зорилт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр тодорхойлсон зорилт нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэлийг хангалттай хэмжээнд илэрхийлж чадсан байна.

Түүнчлэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлыг хуулийн төсөл боловсруулах замаар зохицуулах шаардлагатай эсэхийг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын хүрээнд холбогдох судалгааг хийж үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн, ойлгомжтой байдлаар тодорхойлсон гэж дүгнэв.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтээр:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзсэн.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ уг хуулийг хэрэгжүүлэх гол байгууллагууд болох мэргэшсэн төрийн байгууллагууд энэ хуулийн хэрэгжилтийг хангах боломжтой талаар хариу ирүүлсэн.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг судлахдаа хуулийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, тэдгээр саналуудаас хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг агуулгаар нэгтгэн судлахад

Түүнчлэн хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн байна.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтээр:

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу холбогдох зардлыг тодорхой тооцсон тул энэхүү үнэлгээний тайланд дүгнэлтийг тусгаагүй болно.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан бөгөөд хуулийн төслийг тухайн хуулийн зорилтод нийцүүлж боловсруулсан, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцсэн, давхардаагүй, хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцсэн, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан, хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй, хуулийн төсөлд татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалтыг тусгаагүй, шударга өрсөлдөөнийг хязгаарлах, авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалтыг тусгаагүй байна гэж үзсэн.

5.3. Зөвлөмж

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, төрийн зарим чиг үүргийг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхийн тулд тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор боловсруулсан байна. Хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байна.

---ooOoo---